# БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Сайхан сумын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/101/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ...........................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....................................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........................................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан........................................................................................................
4.1 Ерөнхий зүйл ........................................................................................
4.2 Материаллаг байдал ...............................................................................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.......................................................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...................................................................
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ....................................................

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 217

танай ______ны № ______т

САЙХАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЛХАГВАЖАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 13,033.7 мянган төгрөгийн бараа материал, Орон нутгийн хөгжлийн сангаас 9,748.9 мянган төгрөгийн хангамжийн бараа материалыг, БШУЯ-аас шилжин ирсэн 6,464.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,535.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,565.0 мянган төгрөгийн сурах бичиг, хандиваар 2,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 590.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор “Цалин хөлс шинэчлэн батлах тухай” төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны 1/383 албан тоотоор 2024-2025 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан

ажиллахыг чиглэл болгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 8 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 93 хувьтай дүгнэгдсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **523,909,563.99** | **286,689,831.44** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **457,462,840.83** | **213,986,411.08** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 457,462,840.83 | 213,986,411.08 |
| 31210 | Төгрөг | 457,462,840.83 | 213,986,411.08 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 457,462,840.83 | 213,986,411.08 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **66,446,723.16** | **72,703,420.36** |
| 35100 | Түүхий эд материал | 7,263,245.4 | 8,620,701.4 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,263,245.4 | 8,620,701.4 |
| 35400 | Хангамжийн материал | 59,183,477.76 | 64,082,718.96 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 55,800 | 55,800 |
| 35420 | Аж ахуйн материал | 44,280,595.91 | 48,449,895.91 |
| 35450 | Барилгын засварын материал | 75,000 | 537,400 |
| 35460 | Хүнсний материал | 14,241,681.85 | 15,039,623.05 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 530,400 | 0.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,056,536,466.1** | **1,864,773,426.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,056,536,466.1** | **1,864,773,426.99** |
| 39200 | Биет хөрөнгө | 2,025,884,066.12 | 1,837,033,526.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,359,899,952.99 | 2,359,899,952.99 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -764,739,667.41 | -889,479,480.75 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 387,989,324.69 | 391,137,595.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -105,612,214.3 | -177,617,923.95 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 211,305,593.64 | 236,885,584.64 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -90,887,626.95 | -113,285,861.89 |
| 39217 | Ном | 27,928,703.46 | 29,493,660.26 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 30,652,399.98 | 27,739,900 |
| 39301 | Программ хангамж | 6,350,000 | 450,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,100,000.02 | -112,500 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 27,402,400 | 27,402,400 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **2,580,446,030.09** | **2,151,463,258.43** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **22,700,077** | **0.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **22,700,077** | **0.0** |
| 41300 | Өглөг | 22,700,077 | 0.0 |
| 41360 | Бусад өглөг | 22,700,077 | 0.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 22,700,077 | 0.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,557,745,953.09** | **2,151,463,258.43** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,557,745,953.09 | 2,151,463,258.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 279,506,769.68 | 279,506,769.68 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 279,506,769.68 | 279,506,769.68 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 386,050,725.1 | -20,231,969.56 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 231,150,581.42 | 374,515,040.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 154,900,143.68 | -394,747,010.13 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,892,188,458.31 | 1,892,188,458.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **2,580,446,030.09** | **2,151,463,258.43** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2,625,138,227.25** | **2,480,324,542.8** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **174,167,427.25** | **2,480,324,542.8** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 174,167,427.25 | 35,569,642.8 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,182,900 | 3,525,300 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,683,300 | 3,525,300 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,499,600 | 0 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/ | 0.0 | 2,856,000 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 146,704,115.75 | 16,154,552.8 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 6,280,411.5 | 13,033,790 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 2,444,754,900 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 2,444,754,900 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 2,444,754,900 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 2,450,970,800.0 | 2,444,754,900 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,227,669,100** | **0.0** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,227,669,100 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,227,669,100 | 0.0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,474,295,336.04** | **2,872,950,090.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,474,295,336.04** | **2,872,950,090.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,422,549,150.54** | **2,800,853,642.77** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,560,487,552 | 1,821,638,250 |
| 210101 | Үндсэн цалин | 1,031,985,268 | 1,119,313,387 |
| 210102 | Нэмэгдэл | 505,193,244 | 576,843,874 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 53,850,778 |
| 210104 | Урамшуулал | 23,309,040 | 71,630,211 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 189,500,789.79 | 222,930,929.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 129,080,389.91 | 152,444,248.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 15,678,315.89 | 18,299,413.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 7,816,059.65 | 9,012,487.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 7,385,206.18 | 8,553,325.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 29,540,818.16 | 34,621,455.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 236,520,684.53 | 257,601,384.04 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 14,650,106.44 | 22,784,362.13 |
| 210302 | Түлш халаалт | 221,870,578.09 | 234,817,021.91 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,218,127 | 12,344,934 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 15,218,127 | 12,344,934 |
| 2105 | Нормативт зардал | 125,388,525.36 | 173,940,502.7 |
| 210502 | Хоол, хүнс | 125,388,525.36 | 173,940,502.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засвары зардал | 1,975,500.00 | 11,146,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,975,500.00 | 11,146,750.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 23,236,229.42 | 19,619,263.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.0 | 3,525,300 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,236,229.42 | 16,093,963.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 270,221,742.44 | 281,631,628.28 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,285,270.00 | 47,387,383.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,525,650 | 9,953,116 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 202,410,822.44 | 224,291,129.28 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,721,685.5** | **65,559,066.1** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 51,721,685.5 | 65,559,066.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 51,721,685.5 | 65,559,066.1 |
| 2131 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 24,500.00 | 6,537,381.43 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 24,500.00 | 6,537,381.43 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **150,842,891.32** | **-392,625,547.5** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **7,478,432.06** | **2,121,462.63** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 7,478,432.06 | 2,121,462.63 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **-7,478,432.06** | **-2,121,462.63** |
| **VI** | **1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **143,364,459.15** | **-394,747,010.13** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **2,475,837,000.00** | **2,451,136200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,182,900** | **2,155,551,600** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 21,182,900 | 6,381,300 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,182,900 | 6,381,300 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,683,300 | 3,525,300 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,499,600 | 2,856,000 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 2,444,754,900 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 2,444,754,900 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 2,444,754,900 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 2,444,754,900 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,454,654,100** | **0.0** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,454,654,100 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,454,654,100 | 0.0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,242,326,421.21** | **2,676,117,629.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,242,326,421.21** | **2,676,117,629.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,193,750,071.21** | **2,602,399,843.32** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,560,487,552 | 1,821,638,250 |
| 210101 | Үндсэн цалин | 1,031,985,268 | 1,119,313,387 |
| 210102 | Нэмэгдэл | 505,193,244 | 576,843,874 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 53,850,778 |
| 210104 | Урамшуулал | 23,309,040 | 71,630,211 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 189,500,789.79 | 222,930,929.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 129,080,389.91 | 152,444,248.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 15,678,315.89 | 18,299,413.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 7,816,059.65 | 9,012,487.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 7,385,206.18 | 8,553,325.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 29,540,818.16 | 34,621,455.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 224,985,000.00 | 269,137,068.57 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 13,182,000.00 | 24,252,468.57 |
| 210302 | Түлш халаалт | 211,803,000.00 | 244,884,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 112,017,580 | 173,117,105 |
| 210502 | Хоол, хүнс | 112,017,580 | 173,117,105 |
| 2106 | Эд хогшил, урсгал засвары зардал | 1,975,500 | 18,960,150 |
| 210604 | Урсгал засвар | 1,975,500 | 18,960,150 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,919,529.42 | 33,023,424.8 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,683,300 | 3,525,300 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,236,229.42 | 29,498,124.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 77,864,120 | 63,592,915 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,047,220 | 53,592,799 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,816,900 | 10,000,116 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,576,350** | **73,717,786.43** |
| 2131 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 24,500 | 6,537,381.43 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 24,500 | 6,537,381.43 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,551,850 | 67,180,405 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 48,551,850 | 67,180,405 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **233,510,578.79** | **-224,981,429.75** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **57,443,623** | **18,495,000** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **57,443,623** | **18,495,000** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 57,443,623 | 18,495,000 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 0.0 | 18,495,000 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 57,443,623 | 0.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-57,443,623** | **-18,495,000** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **176,066,955.79** | **-243,476,429.75** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 281,395,885.04 | 457,462,840.83 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 457,462,840.83 | 213,986,411.08 |
| 99 | Хамаарахгүй | 0.0 | 0.0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Данс ны код | Дансны нэр, төрөл | 1. Устгалын өмнөх | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,506,769.68** | **1,895,339,658.31** | **227,999,381.42** | **2,402,845,809.41** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 3,151,200 | 3,151,200 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 279,506,769.68 | 1,895,339,658.31 | 231,150,581.42 | 2,405,997,009.41 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | -3,151,200 | 0.0 | -3,151,200 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 143,364,459.15 | 143,364,459.15 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,506,769.68** | **1,892,188,458.31** | **374,515,040.57** | **2,546,210,268.56** |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **279,506,769.68** | **1,892,188,458.31** | **374,515,040.57** | **2,546,210,268.56** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 279,506,769.68 | 1,892,188,458.31 | 374,515,040.57 | 2,546,210,268.56 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | -394,747,010.13 | -394,747,010.13 |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **279,506,769.68** | **1,892,188,458.31** | **-20,231,969.56** | **2,151,463,258.43** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **2,530,788,700** | **2,451,136200** |
| 12 | Татварын бус орлого | 2,530788,700 | 2,451,136200 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,183,400 | 6,381,300 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 4,327,400 | 3,525,300 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 2,856,000 | 2,856,000 |
| 122 | Тусламжийн орлого | 2,523,605,300 | 2,444,754,900 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,523,605,300 | 2,444,754,900 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,672,477,500** | **2,399,028,029.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,672,477,500** | **2,399,028,029.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,602,714,000** | **2,331,847,624.75** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,028,806,100 | 1,821,638,250 |
| 210101 | Үндсэн цалин | 1,278,469,900 | 1,119,313,387 |
| 210102 | Нэмэгдэл | 715,398,000 | 576,843,874 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 53,850,778 |
| 210104 | Урамшуулал | 34,938,200 | 71,630,211 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 254,266,400 | 222,930,929.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 172,901,100 | 152,444,248.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,341,300 | 18,299,413.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,170,700 | 9,012,487.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,170,700 | 8,553,325.47 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,682,600 | 34,621,455.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 279,084,600 | 269,137,068.57 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 30,700,000 | 24,252,468.57 |
| 210302 | Түлш халаалт | 244,884,600 | 244,884,600 |
| 210303 | Цэвэр бохир ус | 3,500,000 | |
| 2105 | Нормативт зардал | 202,456,600 | 173,117,105 |
| 210502 | Хоол, хүнс | 202,456,600 | 173,117,105 |
| 2106 | Эд хогшил, урсгал засвары зардал | 20,000,000 | 19,910,150 |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000 | 19,910,150 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,612,200 | 33,473,424.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,327,400 | 3,525,300 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 31,284,800 | 29,948,124.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,572,700 | 80,687,915 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,471,000 | 70,687,799 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,101,700 | 10,000,116 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **69,763,500** | **67,180,405** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 69,763,500 | 67,180,405 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 69,763,500 | 67,180,405 |
| 2131 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 6,537,381.43 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | 6,537,381.43 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-440,773,400** | **-243,476,429.75** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **440,773,400** | **243,476,429.75** |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 440,773,400 | 243,476,429.75 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 457,462,840.83 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 213,986,411.08 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,359.8 мянган төгрөгийн 6 зөрчил[1] илэрснээс 1,484.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 6,391.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 34,483.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн асуудлаас зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

### 3.1 Төлбөрийн акт

- *Илрүүлэлт:* Багш нарын баярын арга хэмжээний тэмцээн уралдаанд оролцсон Дуу хөгжмийн багш О.Түвшинжаргалд нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 484.0 мянган төгрөгийн урамшууллыг буруу эрх зүйн үндэслэлээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**3.2 Албан шаардлага**

- *Илрүүлэлт*: Нягтлан бодогч цэцэрлэгийн үндсэн ажилтнаар цалинждаг ч орон тооны хүрэлцээгүй гэх шалтгаанаар сургуульд үндсэн цалинг бүтнээр тооцон 6.391.9 мянган төгрөгийг илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 9 тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2." Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно". гэсэн заалтыг зөрчсөн байна.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Зардлын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт*: Байгууллагад ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагчийн 500.0 мянган төгрөгийн ажлын хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутган төлөөгүй байгаа нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.10."өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан", 7 дугаар зүйлийн 7.4."Энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын төрөлд дараах хүн албан журмаар даатгуулна" гэсэн заалт зөрчигдсөн байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

2. **Худалдан авалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт*: Хүнсний материал худалдан авахдаа тендерийг харьцуулалтын болон шууд худалдан авах аргыг ашигласан гэх боловч тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтлээгүй, хэлэлцээ хийх урилга хүргүүлээгүй тендерийн материал шаардлага хангахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1."Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", 35 дугаар зүйлийн 35.2."Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ". гэсэн заалуудыг зөрчсөн байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт*: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 33.715.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 43 нэр төрлийн 104 ширхэг хөрөнгө бүртгэлтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчигдөж байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**4. Зардлын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт*: Төрийн албан хаагчид олгох эмчилгээний зардлын 268.0 мянган төгрөгийн нөхөх төлбөрийг олгохдоо сугалааны дугаартай баримтаар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 1.3. "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг тухайн байгууллага төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ" гэсэн заалтууд зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үр дүнгийн урамшуулал давхардуулан оолгосон | 1 | 1,484.0 | 1 | 1,484.0 | | | | | | | | |
| Цалин давхар бүтэн орон тоогоор тооцож олгосон | 1 | 6.391.9 | | | 1 | 6.391.9 | | | | | | |
| Хөлсөөр ажилласан ажилтанд НДШ тооцоогүй | 1 | 500.0 | | | | | 1 | 500.0 | | | | |
| Худалдан авах ажиллагааны материал шаардлага хангахгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | 33.715.9 | | | | | 1 | 33.715.9 | | | | |
| Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу | 1 | 268.0 | | | | | 1 | 268.0 | | | | |
| **Дүн** | **6** | **42,359.8** | **1** | **1,484.0** | **1** | **6.391.9** | **4** | **34,483.9** | | | | |